Төрийн тэргүүн ард иргэдээсээ дэмжлэг хүсэв

Эдийн засгаа тэлэх бодлого баримталж, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ. > 2

"Nissan" хохирлыг барагдуулахад 98 сая ам.доллар зарцуулна

"Nissan" компани 4.4 сая ширхэг автомашины асуудлыг шийдвэрлэхээр болсон. > 5

FT FINANCIAL TIMES

■ Солонгосын хямралыг дагаад Швейцар франк чангарав

■ ВНР-Цахилгаан машины зай хураагуурын зах зээлд

Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

"Засгийн газрын мэдээ" сонины цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын долдугаарт бичигдлээ.

- Gogo.mn
- Ikon.mn
- Caak.mn
- Xorom.com
- Zaluu.com
- Unuudur.mn
- Ubinfo.mn
- Medee.mn
- News.mn
- Eagle.mn

Эх сурвалж: Alexa.com©

NNC NATIONAL NEWS CORP | БҮРЭЛДЭХҮҮН КОМПАНИ

ubinfo.mn

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.08.11, БААСАН ~ №150 (696)

ҮНЭ: 600₮

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч зарлиг гаргаж, Хөдөлмөрийн баатар цолоор П.Дамдинг шагнав.

Үндсэн хуулийн өөрчлөлтийн нийслэл дэх хэлэлцүүлэг эхэллээ.

Ерөнхий сайд БНХАУ-ын Гадаад хэргийн яамны туслах сайдыг хүлээн авч уулзлаа.

Монгол, Хятадын стратегийн яриа хэлэлцээний уулзалт боллоо.

Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбогдуулан АН-аас Ажлын хэсэг байгуулав.

ЭДИЙН ЗАСАГ

Монголбанкны үнэт цаасны үлдэгдэл 1.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна.

Хөрөнгийн биржийн индекс 925.76 нэгж болж 1.82 хувиар өсөв.

БНХАУ долдугаар сард 19.46 сая тонн нүүрс импортолжээ.

"Мерекс" хувьцаат компани 33.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.

Даатгалын компаниудын хураамжийн орлого 18.3 тэрбум төгрөгт хүрлээ.

НИЙГЭМ

Геологийн төв лабораторийн уулзварыг ирэх даваа гараг хүртэл хаана.

БХБ-ын салбарын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл 65.8 хувьтай байна.

Тээврийн хэрэгслийн улсын дугаарын хязгаарлалт хэвийн мөрдөгдөж байгаа гэв.

Цэцэрлэгийн цахим бүртгэл энэ сарын 24 хүртэл үргэлжилнэ.

Энэ жил 181 удаагийн түймэр гарч, өнгөрөгч оныхоос 63.6 хувиар өсжээ.

ДЭЛХИЙ

Пентагон Умард Солонгосын объектуудыг бөмбөгдөх төлөвлөгөө боловсруулав.

Швед улс бэлэн мөнгийг 2030 он гэхэд хэрэглээнээс хасна.

Катарын хөрөнгө бүхий Европын банкуудад Арабын Эмират хориг тавина.

Хятадад хамгийн хямд цахилгаан машин бүтээлээ.

Mazda компани хувьсгалч технологитой бензин хөдөлгүүр хөгжүүлж байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.08.11

19° | 10°

ТҮР ЗУУРЫН БОРООТОЙ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 6 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

8 658000 029112 00696

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

"Тэтгэвэр"-ийн тээврээр паркаа шинэчилсээр байх уу

Одоогоос найман жилийн өмнө буюу 2009 онд БНСУ-аас 400 автобус худалдан авснаас хойш энэ салбарт дорвитой хөрөнгө оруулалт хийсэнгүй. ▶3

Б.Ганбаяр / ЗГМ©

УЛС ТӨР

И.Энхболд: Өмнөд Солонгос нөхцөл тавихгүй байгаа

Б.Даваатогтох
@dato.ZGM

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн судлаач И.Энхболдтой ярилцлаа.

Тэрбээр Өмнөд Солонгос нөхцөл тавихгүйгээр шууд хэлэлцээний ширээний ард суух сонирхолтой байгааг онцлов.

-Хойд Солонгос дэлхийн анхаарлын төвд орчихлоо. Энэ асуудалд Өмнөд Солонгос улс ямар байр суурь баримталж байгаа вэ?

-Өмнөд Солонгос албан ёсны байр сууриа илэрхийлээгүй байна. Өөрөөр хэлбэл, Өмнөд Солонгосын байр суурь хэвээр байгаа гэсэн үг. Нөхцөл байдлаас харахад АНУ түрүүлж давших боломжгүй байгаа. Харин Хойд Солонгос эхний алхам хийх магадлал өндөр бий. Учир нь АНУ түрүүлж дайрвал Хойд Солонгос АНУ болон Өмнөд Солонгос руу зэрэг дайрахаа мэдэгдсэн. Нөгөөтэйгүүр, АНУ Хойд Солонгос руу давшихаар болбол нэн тэргүүнд Өмнөд Солонгост байгаа иргэдийгээ нүүлгэн шилжүүлэх байх.

▶2

ЭДИЙН ЗАСАГ

Бодлого гажсан тохиолдолд хөтөлбөрийг эргэж хардаг

Хятадын өсөлт дэлхийн улс орнуудад боломж олгож байна

Г.Илч
ЗГМ

ОУВС-гийн Ази, Номхон далайн бүсийн захирал Ранил Салгадотой ярилцлаа.

-Засгийн газруудыг ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдахаар болсныхоо дараа тус байгууллагаас өгсөн зөвлөмжийг дагахгүй байх тохиолдолд ямар арга хэмжээ авдаг вэ?

-ОУВС-гийн баг тухайн улсад очиж, Засгийн газрын үйл ажиллагаатай нь танилцдаг. Засгийн газар үйл ажиллагаагаа ОУВС-гийн хөтөлбөртэй хэрхэн уялдуулж байгааг хэд хэдэн шатанд шалгалт явуулж дүгнэдэг. Шинээр хэрэгжүүлж буй бодлогууд хөтөлбөрийн зорилготой хэр нийцэж байгааг дүгнэж үзнэ гэсэн үг. Товчоор хариулахад, хөтөлбөрийн хэрэгжилт, түүний зорилт нь Засгийн газрын бодлогод тусгалаа олж, улмаар уялдаж байгааг хардаг. ОУВС-гийн хөтөлбөрийн ерөнхий зорилтууд маш тодорхой. Хөтөлбөрийн дараах үр дүн хамгаас чухал. Тухайн улсын эдийн засгийн бодлого, зорилтууд нь цаашид ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах шаардлагагүй түвшинд хүрсэн байх явдал. Гол зорилго нь энэ. Гэхдээ үүссэн нөхцөл байдал, эрсдэл зэргээс шалтгаалж хөтөлбөр тус бүр өөрийн гэсэн зорилтуудтай байх нь бий.

▶5

ЗГМ: ИНФОГРАФИК

FT FINANCIAL TIMES

Дижитал Америкийн "Их, бүр их"

Рана Фүрүхар

Цалин эрчтэй өсөж буй салбар санхүү, мэдээллийн технологи гэжд хуруу дарам. Гэтэл эдгээр салбарт шинээр үүсэж буй ажлын байрны тоо харьцангуй цөөн. Бүх зүйлийг зээлдүүлэх ажил эрхэлдэг санхүүгийн салбарт АНУ-ын компаниудын нийт орлогын 25 хувь оногддог. Тэгсэн мөртлөө тус салбар ажлын байрны дөрөвхөн хувийг бүрдүүлдэг.

Технологийн салбарт ч эд баялаг, эрх мэдэл бусад аль ч салбараас илүү төвлөрсөөр байна. АНУ-д 25-аас дээш хувийн ашигтай ажилладаг бүх бизнесийн талаас илүүг технологийн компаниуд эрхэлдэг. Технологийн аваргууд-Facebook, Google, Amazon нь хуучин цагийн General Motors, General Electric зэрэг аж үйлдвэрийн группүүдийнхээс төдийгүй, IBM, Microsoft зэрэг өмнөх үеийн технологийн компаниудынхаас ч цөөн ажлын байр шинээр үүсгэж байна.

▶7

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
925.76	1281.00	6372	97.20	100.40	2443.52	366.94	40.80
1.82%	0.32%	0.3%	0.16%	0.02%			

Улс төр

ЕРӨНХИЙЛӨГЧ

Төрийн тэргүүн ард иргэдээсээ дэмжлэг хүсэв

Б.Даваа
ЗГМ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга тангарагаа өргөж, тамгаа гардан авсан цагаас хойш нэг сарын дараа МҮОНТ-ийн "Цаг үе Үзэл бодол" нэвтрүүлэгт оров. Тэрбээр нэвтрүүлгийн эхэнд Ерөнхийлөгч болсноор намын гишүүнчлэлгүй болж байгаагаа онцлов. Мөн УИХ-аас баталсан ч цаасан дээр үлдсэн хөгжлийн хөтөлбөрүүдийг бодит ажил хэрэг болгохын төлөө ажиллахаа амлаж, ард иргэдийн дэмжлэг хэрэгтэй байгааг дурдлаа. Учир нь эрх баригч хүчин болох МАН-ыг энэ чиглэлд анхаарч ажиллахгүй байна гэсэн таамгийг тэрбээр дэвшүүлж, ийнхүү иргэдийн дэмжлэгийг хүсэв. Энэ хүрээнд цаашид эдийн засгаа тэлэх бодлого баримталж, томоохон бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ гэв. Зам тээвэр болон Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байхдаа санаачилсан төсөл хөтөлбөрүүдийг гацаанаас гаргаж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

Тухайлбал, далайд гарцгүй орны хувьд гуравдагч зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахын тулд төмөр зам тавих ёстой. Гэхдээ гаалийн татвар өндөр байгаа тул анхны айлчлалуудаа хоёр хөршөөсөө эхлүүлж, татварын хэмжээг бууруулах талаар яриа хэлэлцээр хийх төлөвлөгөөтэй байгаагаа Ерөнхийлөгч Х.Баттулга онцоллоо. Тодруулбал, үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж, бүтээгдэхүүнээ хоёр хөрш рүү хөнгөлөлттэй гаргах асуудлыг ажил хэрэг болгоно гэлээ.

Үүнээс гадна улс төрийн намуудын санхүүжилтийг ил болгох шаардлагатай байгааг хэлсэн юм. Учир нь хоёр ч удаагийн сонгуульд дамжин яригдсан МАН-ын 60 тэрбум төгрөгтэй холбоотой асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэй байгаа гэв. Энэ хүрээнд АТГ-ын удирдлагыг хоёр ч удаа дуудан уулзаж, хууль хүчний байгууллагын хамтарсан Ажлын хэсэг гаргажээ. Онцлоход, Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч Х.Баттулга эдийн засгийн нөхцөл байдал хүндхэн байгаа цаг үед шийдвэр гаргагчид амарч байгаад шүүмжлэлтэй хандав. [ЗГМ]

СУДЛААЧ ЯРЬЖ БАЙНА

И.Энхболд: Өмнөд Солонгос нөхцөл тавихгүй байгаа

◄1

Мөн АНУ Өмнөд Солонгос дахь цэрэг, зэвсгийн хүчээ зузаатгах шаардлагатай болно. Ийм бэлтгэл хангаж байгаа, эсэх нь тодорхойгүй.

Өмнөд Солонгосын шинэ Ерөнхийлөгч Мун Жэ Ин үүрэгт ажилдаа орсон цагаасаа л дээрх асуудлыг дипломат аргаар шийднэ гэсэн байр сууриа илэрхийлсэн. Энэхүү байр суурь нь өмнөх Ерөнхийлөгч нарынхтай харьцуулахад асуудлыг тайван замаар шийдэхийг хүсэж байна.



Б.Ганбаяр / ЗГМ©

Өмнөд Солонгосын өмнөх төрийн тэргүүн нар Хойд Солонгосыг цөмийн зэвсгийн туршилтаа зогсоосны дараа хэлэлцээний ширээний ард сууна гэсэн байр суурьтай байсан юм. Өөрөөр хэлбэл, Солонгосын үе үеийн Ерөнхийлөгч нар Хойд Солонгос улстай хэлэлцээ хийхдээ хатуу байр суурьтай ханддаг байсан юм. Тэгвэл өнөөдрийн тухайд Өмнөд Солонгос нөхцөл тавихгүйгээр шууд хэлэлцээний ширээний ард суух сонирхолтой байна.

-Асуудал хурцадвал Өмнөд Солонгос улс илүү хохирол амсана шүү дээ?

-Өнөөдрийн хувьд бүх асуудал Хойд Солонгосоос шалтгаалж байна гэж хэлж болно. Учир нь Хойд Солонгос улс л хэлэлцээрийн ширээний ард суух шаардлагатай байна.

Монгол Улсад л талуудын эрх ашиг тэнцвэртэй байж чаддаг

-Өмнөд Солонгосын байр суурь өөрчлөгдөх болсон нь юутай холбоотой вэ?

-Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан Ардчилсан намын байр суурь үеийн үед зөөлөн байсан. Тус нам яриа хэлэлцээний замаар Хойд Солонгостой ойлголцох байр суурийг баримталдаг. Нөгөөтэйгүүр, шинэ Ерөнхийлөгч Мун Жэ Ин өөрөө зөөлөн хүн. Тиймээс хувь хүний харизм болон намын бодлого байр суурийг өөрчлөхөд голлох нөлөө үзүүлсэн гэж бодож байна. Энэ байдлыг Хойд Солонгос ашиглах ёстой. Ийм боломж гарсан байхад хатуурхах шаардлага байхгүй. Хэрэв Хойд Солонгос энэ байр суриасаа татгалзахгүй бол улс төр болон эдийн засгийн хувьд хүндхэн байдалд орно. Энэ бол хувь хүний байр суурь.

-Филиппиний нийслэл Манила хотод болсон АСЕАН-ы уулзалтын үеэр Умард Солонгосын Гадаад хэргийн сайд Ри Ён Хо Өмнөд Солонгосын Гадаад хэргийн сайд Кан Кюн Хатай уулзаж, хоёр талын харилцааг сайжруулах зорилгоор яриа хэлэлцээ хийх санал тавьсан ч Умардын тал татгалзсан хариу өгсөн. Хоёр Солонгос яриа хэлэлцээ хийх боломж бий юу?

-Судлаач хүний хувьд Умард Солонгосын Гадаад хэргийн сайдын гаргасан мэдэгдэлд харамссан. Яриа хэлэлцээний ширээний ард сууж л энэ асуудлыг шийдэх боломжтой гэж бодож байна. Түүнээс биш пуужин харваж, асуудлыг шийдэхгүй. Магадгүй зургаан талт хэлэлцээрийг дахин эхлүүлэх шаардлагатай байх. Гэхдээ Хойд болон Өмнөд Солонгосын төлөөлөл Монгол Улсад хэд хэдэн удаа уулзсан. Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх "Улаанбаатарын яриа хэлэлцээ"-ний хүрээнд талууд өөрсдийн байр суурыг илэрхийлж байгаа. Энэ асуудлыг хөндөж, ярилцах боломж байгаа хэмээн харж байна.

-Монгол Улс Солонгосын хойгийн асуудал төвийг сахисан байр суурийг баримталж буй. Тиймээс "Улаанбаатарын яриа хэлэлцээ"-г дөрвөн удаа зохион байгуулаа. Цаашид энэ байр суурыг хадгалах ёстой юу?

-Байр суурыг хадгалах нь зөв. Монгол Улс Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудалд анхаарал хандуулж, цаашлаад манай улсын хилийн чанад дахь нэр хүнд өснө. "Улаанбаатарын яриа хэлэлцээ"-г зохион байгуулж, Хойд болон Өмнөд Солонгост уулзах боломж олгож байгаа нь гурван улсад ихээхэн ашиг тустай. Бусад улсад энэхүү уулзалтыг зохион байгуулах гэхээр аль нэг талын эрх ашиг давамгайлах хандлагатай болчихдог.

Зөвхөн Монгол Улсад л талуудын эрх ашиг тэнцвэртэй байж чаддаг. Тиймээс Монгол Улс "Улаанбаатарын яриа хэлэлцээ"-г үргэлжлүүлж, цаашлаад Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудалд голлох нөлөө үзүүлнэ. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ҮНДСЭН ХУУЛЬ
Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх нийслэлийн төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтнуудад зориулсан хэлэлцүүлэг боллоо. Хэлэлцүүлэг өнгөрсөн сарын 31-нээс эхлэн ирэх сарын 5 хүртэл улс орон даяар өрнөх юм. Өнөөдрийн байдлаар Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өмнөговь зэрэг найман аймагт зохион байгуулаад байна.

» ЗАСГИЙН ГАЗАР
Барилга, хот байгуулалтын салбарын хэмжээнд өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлт 65.8 хувьтай байгаа аж. Үүнээс Улаанбаатар хотод 87.2, аймгийн төв, суурин газруудад 44.3 хувьтай байгаа юм. Дээрх ажлын хүрээнд цэвэр, бохир ус, ариутгах татуургын 60 гаруй км шугам сүлжээг засварлаж, шинээр 26.5 км шугам сүлжээг барьж ашиглалтад оруулжээ.

» АЖЛЫН ХЭСЭГ
Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг улс орон даяар хэлэлцүүлж байна. Үүнтэй холбоотойгоор Ардчилсан намаас Ажлын хэсэг байгуулжээ. УИХ дахь Ардчилсан намын бүлэг ээлжит бусаар хуралдаж, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлтийн төсөлд Ардчилсан намын санал дүгнэлтийг тусгах ажлын хэсгийг байгуулсан байна. Ажлын хэсгийг УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат ахална.

» ТОО

1.4

Их наяд төгрөг. Ажил олгогч аж ахуйн нэгжийн 2018 оны цалингийн сан 4.7, 2019 он 5.1, 2020 он 5.4 их наяд төгрөг байх тооцоог Хөдөлмөр, нийгмийн хамгаллын яамнаас гаргажээ. Харин төсвийн байгууллагын цалингийн сан 2018, 2019, 2020 онд тус бүр 1.4 их наяд төгрөгт хүрэхээр байгаа аж.

» ХАМТЫН АЖИЛЛАГАА
Монгол, Хятадын ГХЯ-д хоорондын стратегийн яриа хэлцээний гурав дахь уулзалт Улаанбаатарт боллоо. Тавантолгой, Шивээ-Овоо, төмөр зам, гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, хөдөө аж ахуй болон уул уурхайн бүтээгдэхүүнийг үүн боловсруулж Хятадад экспортлох зэрэг тодорхой асуудлыг урагшлуулахад холбогдох байгууллагуудтай Гадаад харилцааны яамдын зүгээс хамтарч ажиллахаар болов.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН ХМХ

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО
Утас. 99997481

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас. 99903584

РЕДАКЦИ
Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Даваатогтох
Утас: 99901637

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас. 99901532

Гадаад контент, соёл энтертайнментын алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА
Э.Энхбаатар
Утас. 99903578

ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
"Блю Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас. 70103131,
Факс. 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
ubinfo.mn

Дугаарын удирдагч
Б.Баяртогтох

8 658000 029112 00696

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

› **OPED@ZASAG.CO**

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ФОТО МЭДЭЭ

Ерөнхийлөгч Х.Баттулга зарлиг гаргаж, Хөдөлмөрийн баатар цолоор төр, нийгмийн нэрт зүтгэлтэн П.Дамдинг шагналаа.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017-08-10

Тендер шалгаруулалтын нэр: **Труба хоолой /ГОСТ-той/сангийн труба/**
Тендерийн дугаар: **МС-56/2017-1**

Дулааны IV цахилгаан станц эрх бүхий тендерт оролцогчдоос Труба хоолой /ГОСТ-той/сангийн труба/-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер иргүүлэхийг урьж байна.
Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
Борлуулалтын хэмжээ: 2016, 2015 оны дундаж борлуулалт нь 215,400,000 төгрөгөөс багагүй
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь 214,100,000 төгрөгөөс багагүй
Санхүүгийн тайлан иргүүлэх жилийн тоо: 2016, 2015 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг иргүүлнэ.
Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2016, 2015 оны дундаж нь 215,400,000 төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ажлыг гүйцэтгэсэн туршлагатай байна
Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл иргүүлэх эсэх: Шаардахгүй
Тендерийн хамт 4310000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа иргүүлнэ.
Тендерийг 2017 оны 09 -р сарын 11-ны өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө доорх хаягаар иргүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 09-р сарын 11-ны өдрийн 10 цаг 30 минут-т нээнэ.
Гадаадын этгээд тендер иргүүлэх эрхтэй эсэх: Эрхтэй
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол, Улаанбаатар, Баянгол дүүрэг Эрчим хүчний гудамж,
ДЦС-4 ХК ХААХ, Утас: 70171284 , Факс: 70171284
Имэйл хаяг: info@tpp4.mn, Веб хаяг: www.tpp4.mn

ЗГМ: Сэдэв

"Тэтгэвэр"-ийн тээврээр паркаа шинэчилсээр байх уу

Үйлчилгээнээс гарах шаардлагатай 250 автобус үйлчилгээнд явж байна

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Б.Ганбаяр / ЗГМ©

Нийтийн тээврийн салбарт парк шинэчлэл хийх цаг нь болжээ. Одоогоос найман жилийн өмнө буюу 2009 онд БНСУ-аас 400 автобус худалдан авснаас хойш энэ салбарт дорвитой хөрөнгө оруулалт хийсэнгүй. Улсын хэмжээнд 2720 том, дунд, жижиг оврын автобус нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаагаас 1700 орчим нь нийслэлчүүдэд үйлчилж буй. Гэтэл эдгээрийн дийлэнх нь 8-9 жилийн насжилттай болжээ. Стандартад зааснаар 12 жил болсон автобусыг нийтийн тээврийн үйлчилгээнээс чөлөөлөх ёстой. Энэ жилийн тухайд насжилт нь гүйцэж, "тэтгэвэр"-т гарах шаардлагатай 250 автобус үйлчилгээнд явж байна. Ердөө 2-3 жилийн дараа 1000 гаруй автобус ашиглалтаас гарах тооцоотой. Гэтэл өнөөдөр чөлөөндөө гарах ёстой 250 автобусыг орлох нь бүү хэл шинээр авахаар төлөвлөсөн нэг ширхэг ч автобус алга. Одоогийн байдлаар ашиглалтаас гарсан 250 автобусны 50-ыг нь үйлчилгээнээс халж, үлдсэнийг нь нийтийн тээвэрт явуулахаас өөр сонголтгүй байгааг нийслэлийн Тээврийн газрын мэргэжилтнүүд хэлж байна. Эндээс дүгнэхэд парк шинэчлэл хийх боломжгүй гэсэн шалтгаанаар хэдийнэ 12-18 жилийг элээсэн, хэзээ мөдгүй зогсолт хийхэд бэлэн хуучин автобусаар иргэдийг тээвэрлэж байна.

Удахгүй хичээлийн шинэ жил эхэлж, их хотын хөл хөдөлгөөн ихэснэ. Иргэдийн хамгийн ихээр бухимддаг асуудлын нэг нь нийтийн тээврийн үйлчилгээ. Угтаа нийтийн тээвэр өглөөний 07.00 цагаас үдшийн 22.30 минут хүртэл иргэдэд үйлчлэх үүрэгтэй. Гэвч өвлийн улиралд гэгээ тасармагц автобусуудын бараа сураг алдарч, иргэд олон цагаар буудал дээр хонох нь холгүй хүлээх шаардлагатай болдог. Ялангуяа, захын хороллын чиглэлийн автобусууд өдрийн од шиг ховорхон болсон гэхэд хилсдэхгүй. Автобусны хүрэлцээ муугаас иргэд хохирч, хэдэн цагаар ч хамаагүй автобус хүлээж, буудал дээр жиндэж зогсоход хүрч байна. Эндээс харахад, нийтийн тээврийн үйлчилгээ ямар хэмжээнд байгааг үнэлж болохоор. Уг нь цахим карт нэвтрүүлж, гаднын жишиг рүү ойртож байгааг сайшаах нь зүйтэй. Гагцхүү насжилт өндөртэй автобусуудыг акталж, орон зайг нөхөх зохицуулалт хэрэгтэй боллоо. Тиймээс энэ асуудлыг нэн даруй зохион байгуулалтад оруулах цаг нь хэдийнэ болжээ.

Зорчигч тээврийн нэгтгэлийн захирал Г.Төмөрбаатар "Өнөөдрийн байдлаар нэгтгэлийн хэмжээнд 367 тээврийн хэрэгсэл бий. Нийтийн тээвэрт явдаг автобусны дийлэнх нь насжилтын хугацаа дуусаж байгаагаас гадна сэлбэгийн тоног төхөөрөмж нь ч олдохоо больсон. Хэтрүүлж хэлбэл, үйлдвэрлэж, нийлүүлсэн улсдаа ч байхгүй болсон учраас парк шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай байна. Хамгийн сүүлд 2009 онд парк шинэчлэл хийсэн. Тухайн үед шинэчилсэн тоног төхөөрөмж эхнээсээ муудсан. Нөгөө талаар парк шинэчлэлийг хийхдээ засвар үйлчилгээг орхигдуулахгүй байх зарчмыг барих нь чухал. Манайхан парк шинэчилнэ гээд олноор автобус авдаг. Гэтэл шинэ автобусаа дагаад сэлбэг, засвар үйлчилгээ орхигддог" гэв.

2009 онд орж ирсэн автобусуудын эд анги элэгдэж, муудсан

Нөгөөтэйгүүр, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүд хөрөнгө мөнгөнөөс шалтгаалаад Солонгост хэдийнэ "тэтгэвэрт" гарсан автобус оруулж ирж, паркаа шинэчилж буй. Үүнээс шалтгаалан Солонгост зургаа, Монголд найман жил явсан насжилт өндөртэй автобусууд хар тугалга, азотын исэл гэх мэт хүний биед хортой бодис ялгаруулж байна. Өнгөрсөн долоо хоногт нийслэлийн Тээврийн газраас автобусуудын утаанд хэмжилт, шалгалт хийжээ. Тэд зүүн чиглэлийн 318 автобусны утаанд хэмжилт хийхэд 80 нь MNS 5014:2009 улсын стандартаас илүү хэмжээгээр хорт утаа ялгаруулж байсныг тогтоожээ.

Уг нь гадаадаас өндөр өртөгтэй, хуучин автобус худалдан авахын оронд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих нь хамгийн зөв алхам баймаар. Үндэсний "Экобус" компанийн үйлдвэрлэсэн Евро-4 хөдөлгүүртэй, байгаль орчинд ээлтэй 20 эко автобусыг үйлчилгээнд нэвтрүүлсэн. Цаашид нийтийн тээврийн парк шинэчлэлийг үндэсний үйлдвэрлэгчдэд даатган, монгол инженерүүдийн гараар байгаль орчинд ээлтэй автобус зохион бүтээхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байгааг мэргэжилтнүүд онцолдог. Энэ талаар Зам, тээврийн хөгжлийн яамны мэргэжилтнээс тодруулахад "Солонгосын "Экзим" банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд удахгүй шинэ автобуснууд орж ирнэ. Яам автомашинаас ялгарч байгаа утааг багасгах зорилгоор дизель хөдөлгүүртэй биш, хийн түлшээр ажилладаг автобус оруулж ирэх саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Бид үе шаттайгаар нийтийн тээврийн хэрэгслийг дизелээр биш хийгээр ажилладаг болгох бодлого баримтална" гэлээ. [ЗГМ]

ЗГМ: ИНФОГРАФИК

ЗГМ: ТОДРУУЛГА

Парк шинэчлэл хийхээр тооцож, судалсан

Автобусны парк шинэчлэл болон нийтийн тээврийн техникийн бүрэн бүтэн байдлын талаар нийслэлийн Тээврийн газрын орлогч дарга Х.Булгаагаас дараах зүйлийг тодрууллаа.

-Танайх парк шинэчлэл хийхтэй холбоотойгоор төсөл боловсруулсан уу?

-2009 онд 400 автобус авч байснаас өөр парк шинэчлэл хийгээгүй. Эдгээр автобус 2-3 жилийн дараа үйлчилгээнээс гарна. Тиймээс дараагийн парк шинэчлэлийг одоо ярьж, иргэдэд найдвартай, аюулгүй тээврийн хэрэгслээр үйлчлэх зайлшгүй шаардлагатай байна. Тиймээс бид гадаадын зээл тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар автобусны парк шинэчлэл хийхээр холбогдох газруудад тооцоо судалгаагаа өгсөн байгаа.

-Нийтийн тээврийн хэрэгслийн стандартад заасан насжилт хэд хүртэл байдаг вэ. Үйлчилгээнээс чөлөөлөх автобус байгаа юу?

-Стандартад зааснаар 12-оос дээш жил ажилласан тээврийн хэрэгслийг үйлчилгээнээс халах журамтай. Стандартын шаардлага хангахгүй нийтийн тээврийн 250 гаруй автобус байгаагаас 50 автобусыг үйлчилгээнээс чөлөөлөөд байна. Үлдсэн 200 автобусыг энэ жилдээ багтаан үе шаттайгаар шинэчилнэ.

-Оронд нь автобус авах уу?

-Ойрын гурван жилийн хугацаанд үүсэж мэдэхээр байгаа нэг том бэрхшээл нь нийслэлийн хэмжээнд үйлчилгээнд гарч буй нийт 1200 автобусны 70-80 хувь нь ес орчим жилийн насжилттай болсон. Өвлийн улиралд өдөрт 950 орчим автобус, троллейбус үйлчилгээнд гарч, дунджаар 700-800 мянган хүн тээвэрлэдэг. Харин зуны улиралд зорчигчдын урсгал буурч, 860 орчим тээврийн хэрэгсэл үйлчилгээнд явдаг. Тиймээс манай салбарт парк шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай. [ЗГМ]

Kempinski Hotel Khan Palace
ULAANBAATAR

Барилгын засварын ажлын тендерт урьж байна

ТЕНДЕРИЙН ЗОРИЛГО:

"Хаан Палас" ХХК-ийн хэрэгжүүлж буй Рестораны засварыг хийж гүйцэтгэх

ТЕНДЕРИЙН ДУГААР: **KIULN-15/346**

ТЕНДЕРИЙН МАТЕРИАЛ:

Оролцогчид нь "Таван Богд Трейд" ХХК-ийн оффист хүрэлцэн ирж засварын ажлын зураг болон ажлын даалгаврыг авах ба Тендерт оролцохыг хүсэгчдэд материал хүлээлгэн өгөх сүүлийн хугацаа 2017.08.18-ны 17:30 цаг хүртэл байна.

Тендерт оролцогч байгууллагууд дараахи материалуудыг бүрдүүлж ирүүлнэ.

1. Тендерт оролцох хүсэлт
2. Байгууллагын танилцуулга
3. Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан
4. Гүйцэтгэсэн ажлын танилцуулга
5. Засварын ажлыг гүйцэтгэх нарийн задаргаа бүхий үнийн санал
6. Засварын ажлын график төлөвлөгөө
7. Засварт ашиглах материалын мэдээлэл

Барилга объектын байршил: Зүүн 4-н зам Кемпински зочид буудлын 1-р давхарын Тэнгэр Рестораны засварын ажил

Материал, үнийн санал хүлээн авах хугацаа, хаяг: 2017.08.18-ны 15:00 цаг хүртэл
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Таван Богд Группын төв оффис, 1-р давхар, Тендерийн хайрцаг

И-мэйл хаяг: tender@tavanbogd.com

Утасны дугаар: 99184354, 99903148
"Таван Богд Трейд" ХХК

kempinski.com

Kempinski
HOTELIERS SINCE 1897

Судлаачийн үг

Энэ нэг залхуутай “е-е-е” гэсэн улигт хөгжмийг хогийн саванд чих

“Хүйтэн дайн”-ы төмөр хөшгийг тэд нэвтэлж коммунист үзэл суртлыг ялсан

Олхонуд Баярхүү
профессор

Өнөөгийн энэ даяаршил гэж нэрлээд буй үзэгдлийн анхдагч хүчин зүйл нь рок-поп хөгжим байсан.

Ерөөсөө бүх иргэдээ хянах нь социалист, коммунист нийгмийн гол мөн чанар. Хяналтын олон шатлалт, төрөлжүүлсэн систем байна. Сонгодог, гарт баригдаж, нүдэнд харагдах нь манайхны НАХЯ-ны (До яам) сүлжээ, мэдээлэгчид, гүйцэтгэгчид, цээрлүүлдэг аппарат. Энэ байгууллагын хараа хяналтад орж, сануулга шийтгэл амсвал цаад хүн, гэр бүл дуусах нь тэр. Тухайн үеийн цорын ганц эрх баригч МАХН-ын олон шатны сахилгын шийтгэлийн сүлжээ гэж бас нэг харанга байсан. Намын гишүүддээ хамаатай юм болов уу гэтэл цаад намын гишүүний ар гэр, үр хүүхдэд ял зэм нь давхар очоод наалдчихна. Үйлдвэрчний эвлэл, хяналтын байгууллагатай байсан бол тэр нь далд нууц байсан байх. Харин МХЗЭ, Монголын пионерын байгууллагад сахилгын ба хяналтын сүлжээ байсан. Эвлэлийн шугамаар ял сонсох нь түгээмэл байсан байх. Хардаж цагдах нь улс төрийн дэглэмийн мөн чанар тул бүхнийг хавтгайруулан хянадаг энэ тогтолцоог тоталитари гэж нэрлэдэг.

Тийм дэглэмд эрх чөлөө, тэр дундаа үзэл санаа, урлагийн эрх чөлөө гэж даанч зай байхгүй. Рок хөгжим, панк, хиппи гээч шулмын үзэгдлүүд Европ дахь ийм дэглэмүүдийн хүчийг сулруулж эцэст нь нураах хөрс болсон нь тайлагдашгүй оньсого. Ардчилсан Герман гэж халдашгүй дархан эрхтэй коммунист улс байв. Муу нэрээ түүхэнд мөнхөлсөн “Штази” гэж нууц цагдаагийн алба нь нацистын Германы Гестапог тэр чигээр нь хуулчихсан, Зүүн Германы бүх хүн ардыг хатуу цагдаж байв. Баруун Берлинийг хана хэрмээр бүсэлсэн тул тэндээс элдэв “хорт үйл” орж ирэхийг хаачихлаа гэж байтал хөгжим, дуунд хил хязгаар, хана хэрэм хамаагүйг коммунист удирдагчид гэнэ алдаад мэдсэнгүй.

1960-аад оны эхнээс Баруун Европт рок хөгжим, панкийн давалгаа үүсч, энэ үйлсийг Британи хошуучилж, тэндээс ХБНГУ руу ямар ч цензургүй нэвтэрч байлаа. Европыг битломани бүрхэж, залуус өвчилж эхлэв. Нөгөөх нь Берлиний хана даваад ороод ирэх нь тэр. “Энэ нэг залхуутай “е-е-е” гэсэн улигт хөгжмийг хогийн саванд чих!” хэмээн БНАГУ-ын удирдагч хатаагдсан коммунист Вальтер Ульбрихт намын хурал дээрээ үүрэг өгчээ. Гай таарч тэр “е-е-е” нь нийгмийг насны ангиллаар талцуулчихав. Залуус тэр “е-е-е”-д соронз адил татагдаж байгааг нь ахмад хижээл насныхан зүрх шимшрэн жигшин харж байлаа. Яг ийм үзэгдэл Дорнод Европын бүх социалист орныг нэрвэсэн, СССР руу нэвтэрсэн, хаялга нь алс холын Монголд ч хүрсэн билээ.

Тэрхүү “е-е-е”-ний хөгжмийн аяс, амт, эстетикт коммунист ахмадууд түгшиж байсан хэрэг биш, харин тэрхүү “е-е-е”-гээр дамжаад залуус нь барууны улс төрийн байгуулал-капитализмыг таашаах вий, тийшээ татагдах вий гэдгээс үхтлээ айж байлаа. “Е-е-е”-гийн нөлөөгөөр залуус нь өөрийн шинэ соёлын хувилбарыг коммунист нийгэмдээ буй болгож байлаа. Рок-н-рол хэмээх танцыг хуулбарлан Дорнод Германд “липси” хэмээх “социалист танц” үүсгэв. “Эстрад урлаг”, дагшаа найрал хөгжим, цахилгаан хөгжим нэрээр социалист ертөнц тэр чигтээ “битломани”-ийн хуулбар боллоо.

Зөвхөн оройн цагаар, ажилчин залуусын үдэшлэг дээр тавьж сонсго хэмээн квот тогтоож үзэв. Залууст зориулсан социалист агуулгатай, цэрэг-эх оронч эстрадын соёл тогтоох гэсэн нь үлгэр, инээдэм боллоо. Эрх баригч намуудын Төв Хорооны үзэл суртлын хэлтэс, түүний мэдлийн хүчирхэг аппарат социалист ертөнцийн залуусыг капиталист урлагаас хамгаалах үүрэгтэй хоршин ажиллаад нэмэргүй. Хориглоод байхлаар нь залуус радио хүлээн авагч ашиглан барууны радиостанцуудын долгионуудыг барьдаг болов. Хиппи, Панк-рок хөгжүүлэх гэсэн залуус барууны моод, хэв маяг, жинсэнд автав. Дээрээс нь нам, эвлэл нь дарамтлаад дийлдэггүй ээ.

1969 онд коммунист Германы нураах шахуу үйл явдал гэнэт тохиолоо. Баруун, Зүүн Берлиний хананы ойролцоо английн Rolling Stones хамтлаг тоглолтоо хийнэ гэх сураг дэгдэв. Үнэндээ Rolling Stones-ын дуунуудыг цагаан хоолойгоор Зүүн Берлиний хана туургыг нэвт чарлуулжээ. Rolling Stones-ын концертыг сонсохоор германы хэдэн түм, буман залуус гудамжинд гарчээ. Ядаж байхад БНАГУ байгуулагдсаны 20 жилийн ойн босгон дээр тэгдэг нь ч өдөөн хатгалга болж “Штази”-д хүрчээ. Ардчилсан Германы залуус паникт автжээ. Берлиний хана руу дөхөж ирж дуу сонсох гэсэн залуус болгон дээр хавтаст хэрэг нээжээ. Баривчлагдсан, хоёр гурван жилээр заагдсан хүн ч нэлээд байна. Хананы ойролцоох байшингийн дээвэр дээр шувуу шиг суусан үй олон герман залуусыг барьж хүчрэх биш. Үнэндээ хориглож чадаагүй юм. Барууны хөгжимд дурлагсад хот хөдөөгүй тоо нь өсч үржлээ. “Штази” залуусыг хардаад байсан болохоос хөгшчүүлийг хяналтаасаа гаргачихжээ. Баруун Германд ах дүүсдээ зочилсон хөгшчүүл барууны хитүүдийн пянз бичлэг зөөвөрлөнө чинээ санасангүй. Баруунд байгаа ахан дүүс нь бэлэг бэлгийн дээдийг чухам олж харжээ. Дайсан, хоцрогдсон гэж үздэг орнуудаас бэлэг цувж гарав.

Социалист ертөнцөд нэг иймэрхүү дүр зураг явсаар 1980-аад оны дунд үе хүрч Горбачевын эринтэй золгожээ. Зөвлөлтийн коммунист хяналт энд тэндгүй суларчээ. Дорнод Германыг зөнд нь орхижээ. Зүүн Берлинийг чиглүүлсэн хөгжим, концерт улам чанга цуурааталаа. Рок хөгжим коммунист ертөнцөд нийгмийн байгуулалд хэрхэн нөлөөлж байгааг барууныхан олж харсан төдийгүй уухайлан дэвэргэх нь тэр. Унгар, Чехословак, Югослав руу барууны дуучид хамтлагууд цувж эхлэв. Хүүхэд, залуу насаа хөгжимд донтуулсан шинэ үеийнхэн цагдаа, дотоодын хамгаалахад гараад иржээ. Тэд фанат байснаа чекист болоод нэмэр болсонгүй. Берлин хотын цагдаагийн газрын дэд дарга Дитер Дитце гэх нөхөр яг үүний сонгодог жишээ юм. Боб Дилан, Брюс Спрингстин гэхчлэн дэлхийн рокийн одууд Берлинд тоглов. Эрх чөлөөний мэдрэмжийг тэд дуугаараа мэдрүүлэв. БНАГУ-ын 100 мянган залуусын өмнө “Born in the USA” дуу хангинахад 100 мянгуулаа дагаад хоороор дуулна гэдэг коммунист Германыг хөмөрчих шахсан үзэгдэл биш гэж үү? БНАГУ, “Штази” түүхнээс арчигдах эхлэл биш гэж үү? Хянаж цагдах, коммунист үзэл шингээх гэж дэндүү их цаг хугацаа алдсанаа “Born in the USA” хэмээх хоор дуунаас эрх баригчид нь олж мэджээ.

Горбачевын эринээс 30 жилийн тэртээ Зөвлөлтийн коммунистууд рок-н-роллтой байлдаад эхэлжээ. 1957 онд Москвад дэлхийн залуучууд оюутны их наадам тохиох үеэс эхлэлтэй. Тэр үеэр Зөвлөлтийн иргэд анх удаа рок-поп дуу хөгжмийн зах зухтай танилцжээ. 1960-аад оны эхээр СССР рок-хөгжим далд нууц байдалд оршиж эхлэв. Америкийн ритм-энд-блюз, Британийн “биг-бит” пянз хэлбэрээр Зөвлөлт рүү нууцаар нэвтэрч тархаж эхлэв. “Битлз”, “Роллинг стоунз” -ын дуунууд орос залуусыг донтуулж эхэлжээ. Орос залуус тэссэнгүй 1960-аад оны дунд үе гэхэд өөрийн бит-группээ ил болгожээ. Анхны рок-ансамбль нь Москвад “Славяне”, “Странники”, “Мифы”, “Скоморохи”, Ленинградад “Авангард”, “Лесные братья”, Минскэд “Песняры” хэмээн тодров. Тэднийг хуульчиллаа. Гэхдээ “Зөвлөлтийн эстрад” гэсэн шошготой. Оросоороо “дуу, хөгжмийн хамтлаг” гэсэн даруухан нэртэй. “Веселые ребята”, “Поющие гитары” гэж тэр үеийн монголын залууст хүрсэн нэртэй хамтлагийг нэрлэж болно.

Ах дүү социалист орнуудын соёлын солилцоогоор Польш, Унгараас жинхэнэ рок хамтлагууд Зөвлөлт рүү зочлон тоглоод, ганц нэг нь Монголд ч ирж байв. 1970-аад оны хоёрдахь хагас гэхэд СССР-т рок-н-роллыг албан ёсоор хүлээн зөвшөөрлөө. “Мелодия” хэмээх студэд “Мелодии и ритмы зарубежной эстрады” хэмээх пянз хэдэн саяараа үйлдвэрлэн худалдаанд гаргав. Элвис Пресли, Том Жонс хэмээх барууны поп-рок хитүүдийг монголчууд бид “Мелодия” -аас анхлан сонссон доо. Зөвлөлт улсад аялан тоглолтоор Клифф Ричард, Элтон Жон, “Boney M” гэх диско-хамтлаг ирж цахиур хагалав. Польшийн Сопот, Болгарын Наран эргээс орчин үеийн дуу хөгжмийн наадмуудыг шууд нэвтрүүлдэг боллоо. Балти хавийн улсуудад рок-фестиваль зохиогоод эхлэв. “Ардын дууны” нэрээр Вильнюс, Таллин, Тарту хотод рок-хөгжим цэцэглэв.

“Зөвлөлтийн эстрад” цэцэглэсний өртөг хожим коммунист нам, зөвлөлт төрд маш өндөр өртөгтэй туссан билээ. “Зөвлөлтийн эстрад” -ад тархиа идүүлсэн зөвлөлтийн залуус коммунизмын материал-техникийн баазын бүтээн байгуулалтад гутарчээ.

Энд би сайн санаж байна. 1978 онд “Boney M” Москвад Кремлийн их хурлуудын том танхимд тоглосныг “Орбит” ТВ-ээр Улаанбаатарт шууд үзүүлж, дараа нь Монголын радиогоор тусгай нэвтрүүлэг болгон цацсан юм. Карибын тэнгисийн арлуудын хар арьст дуучин залуус (ямайкийн дуучин Лиз Митчелл, Марсия Баррэтт, Монтсеррат арлын бүжигчин Мэйзи Уильямс, Аруба арлын бүжигчин дуучин Бобби Фаррелл) Орос орныг жинхнээсээ доргиосныг бид харсан, сонссон. “Хүйтэн дайн”-ы төмөр хөшгийг тэд нэвтэлж коммунист үзэл суртлыг ялсан юм.

Тэд зөвлөлтийн ТВ-д ярилцлага өгч байгааг хараад бид шооконд орсонсон. “Таны хүсэл юу вэ?” гэсэн асуултад хариулахдаа “Бид социализм, коммунизмыг хүсч байна”, “Гал улаан туг хүсч байна” гэх болов уу гээд нүдээ чилтэл ширтээд байтал байдаггүй шүү. “Бид аз жаргалыг хүсч байна”, “Бид хайр сэтгэл хүсч байна” гэх нь тэр. Тэд бүр давраад Улаан талбайд видеоклип хийлгээд тавьчихав. Өмнө нь хэн ч ингэж зориглоогүйсэн. “Boney M хамтлагийн үдэшлэг -Останкино концертын танхим” гэсэн нэртэй телешоуг нэрт найруулагч Евгений Гинзбург гэх эсэргүү жүүд нөхөр дэглээд тавьчихлаа. Тэр нь кино-концерт болоод 1979 оны хаврааас Зөвлөлт даяар түглээ. Харин Ю.Андроповын өнгөн дээр Зөвлөлтийн КГБ нөгөө телешоуны бичлэг бүхий кино-концертыг Зөвлөлт даяар ангуучлан нэг бүрчлэн устгалаа. Гэлээ гээд коммунизмын нуралтыг зогсоож чадаагүй юм даа.

Барууны хөгжмийн фэнүүд анхлан Монголд (үнэндээ бол Улаанбаатарт л даа) 1950-иад оны сүүлчээр гарч ирцгээсэн юм билээ. Ихэвчлэн Дорнод Европын социалист орнуудад сурдаг оюутнууд тэдний анхны элч түүчээ байсан юм. “Шилээ дарсан үстэй, шилбээ барьсан өмдтэй” гэсэн хоч нэрийг нийгмээс тэдэнд хайрлаж, “Матар” (сүүлдээ “Тоншуул” болсон) сэтгүүлд тэднийг шоглон зурдаг байв. Тэд үнэхээр үсээ урт ургуулдаг моодыг манайд авчирсан, тэд зузаан ултай гутал, том хар шил, цэмбэн пиджак, дөрвөлжин хээтэй хурц өнгийн цамцыг Монголд дэлгэрүүлсэн. Тэр үедээ этгээд гэмээр ийм хувцастай цэвэрхэн залуус зундаа Улаанбаатарт үзэгддэг, “Чарлстон” хэмээх америк бүжиг хийдэг, тэдний гол төлөөлөгч нь миний мэдэхээр “Элдэв-Очир” кино театрын зураач Я.Үржнээ (хожмын Төрийн шагналт нэрт зураач) байна. Дараахан нь шөвгөр гутал моодонд орж, “Твист” бүжиг дэлгэрч эхэлсэн. АНУ-д Chubby Checker хэмээх дуучин ид мандаж байх үед түүний дам нөлөөгөөр рок-поп хөгжмийн урлаг Монголд эхлэлээ тавьсан юм. Чехословакт сурдаг Х.Төмөр (хожмын хурандаа, мөн нэрт орчуулагч) гэдэг оюутан Chubby Checker, твист хоёрыг анхлан оруулж ирсэн болов уу. Дараахан нь дуучин Төмөр (Зууны манлай дуучдын нэг), нэрт жүжигчин Шороотын Цэвээний хүү Оросхүү, тэр үеийн вальсын хаан гэгддэг хөгжмийн зохиолч З.Түмэнжаргал нар барууны хөгжмийн элч төлөөлөгчид болцгоосон юм. Эдний гавьяа (монголчуудыг төрөл арилжуулахад) баларшгүй ээ.

Өнөөгийн энэ даяаршил гэж нэрлээд буй үзэгдлийн анхдагч хүчин зүйл нь рок-поп хөгжим байсан гэх онол бараг зөв байх. Тэр онолыг зөвшөөрөгчийн нэг нь би өөрөө юм. Би ба миний үеийнхэн өөрсөд дээрээ туршсан биет жишээ. Миний сайн санаж байгаагаар бол эхний алхам нь, анхлан 1960-аад онд Улаанбаатарын ганц нэгхэн сэхээтэн (ихэвчлэн дипломатч) айлуудаар “The BEATLES” хэмээх хамтлагийн пянз үзэгдэж, хотын сэхээтний хүүхдүүд хошуурч, эрэл сурал болж байснаас эхлэн Монголын социалист нийгмийн байгуулал нурах гараагаа авсан гэж дүгнэвэл хилс болох уу?

“Beatles”-т зориулсан хөшөөг Улаанбаатарын унаган иргэдийн нутаг болох 40 мянгатад, Их дэлгүүрийн чанх урд 2008 онд босгож билээ.

Эдийн засаг

БАЙР СУУРЬ

Бодлого гажсан тохиолдолд хөтөлбөрийг эргэж хардаг

IMF©

◀1

Тухайлбал, Монгол Улсад хэрэгжиж байгаа хөтөлбөр хэд хэдэн гол зорилтуудтай байгаа. Эдгээрийн нэг нь улсын өрийг хязгаарлах. Мөн валютын ханшийн бодлогыг энд дурдаж болох юм. Засгийн газар амлалтаасаа буцах, эсвэл бодлого өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хөтөлбөрийн зорилт биелэхгүй байх нөхцөл үүсдэг. ОУВС-гийн баг үүний учир шалтгааныг тодорхойлохоос гадна цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар ярилцдаг.

-Хэрэв Засгийн газар амлалтаа биелүүлээгүй тохиолдолд ОУВС-гийн хөтөлбөрийг царцааж болно гэж та хэлж байна уу?

-Тиймээ. Өмнө нь ийм зүйлүүд болж байсан. Хамгийн ойрын жишээ гэхэд Азийн зарим оронд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдэд ийм байдал үүссэн удаатай. Тухайлбал, Шри Ланк байна. Тус улсын хөтөлбөрийн хоёр дахь удаагийн шалгалт хойшилж байсан. Шалтгаан нь Засгийн газартай нь холбоотой. Ашиг орлогын мэдүүлгээ парламентдаа танилцуулах ёстой хугацаандаа Засгийн газар нь танилцуулаагүйгээс энэхүү байдал үүссэн. Гэхдээ Засгийн газар нь мэдүүлгээ танилцуулж, хоёр дахь шалгалтаа одоогоос долоо хоногийн өмнө хийж дуусгасан. Монголд ажилласан баг хөтөлбөр хэрэгжилтээсээ бага зэрэг гажсан гэж үзвэл үүнтэй нэгэн адил зүйл болж болох юм. Магадгүй санхүүгийн хувьд хүрнэ гэж төлөвлөж байсан хэмжээндээ хүрч чадахгүй бол зорилтоос хэр хэмжээнд зөрөхөөр байгааг тооцоолж, зорилгоосоо хазайх болсон шалтгаан нь хэр зөв, оновчтой шийдвэр байсныг тогтооно. Мөн эргээд хөтөлбөрийг хэрэгжих боломжтой замд нь оруулахын тулд яг юу хийх хэрэгтэй вэ гэдгийг зөвлөнө.

Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлэх хэрэгтэй

-Манай улс түүхий эдэд тулгуурласан эдийн засагтай. Дэлхий дахинд түүхий эдийн ханш нэг их сэргэхгүй байна. Таны хувьд таваарын зах зээлийн үнийн уналттай холбоотойгоор бүс нутгийн хэмжээнд хэр их эрсдэл байна гэж харж байна вэ?

-Таваарын зах зээлийг хоорондоо маш их ялгаатай учраас салгаж харах хэрэгтэй. Нэг нь эрчим хүчний таваар. Нөгөө нь хөдөө аж ахуй, бусад гэсэн ангиллыг энд авч үзэх хэрэгтэй. Экспортын орлогын эх үүсвэр болж буй нүүрс эрчим хүчний таваарт хамаарч байгаа. ОУВС-гийн хувьд зах зээлүүд хэр байгааг ажигладаг. Түүнээс ямар нэгэн төлөв гаргаж, таамаг дэвшүүлдэггүй. Монголын түүхий эдийн экспортыг харвал нүүрс болон бусад металл голлож ирсэн. Монгол Улс далайд гарцгүй. Энэ нь бүс нутгийн зах зээлийн хамаарлыг нэмэгдүүлж байна. Металлын зах зээл дээр Хятадын нөлөө маш их байгаа. Монголын түүхий эдийн зах зээлийн тухай ярихын тулд Хятадад юу болж байгааг харах хэрэгтэй. Хятадад нүүрсийг олон төрлөөр хэрэглэж байгаа. Тиймээс хамгийн түрүүнд аж үйлдвэрийн салбарын байдлыг харах нь чухал.

-БНХАУ нүүрсээр ажилладаг үйлдвэрүүдээ хааж, металлын салбар нь удааширснаар урт хугацаандаа манайд сөргөөр нөлөөлөх байх?

- Тийм ээ, таны хэлж байгаа зүйл урт хугацааны эрсдэл гэж бодож байна. Урт хугацаандаа Хятад улс эрчим хүчний хэрэглээгээ зохистой, үр ашигтай болгох тал дээр анхаарах болно. Үүнд хэд хэдэн шалтгаан байгаа. Түүний нэг нь агаарын бохирдол.

-Байгаль орчин, цаг уурын өөрчлөлтийн асуудал тулгамдаж байгаа энэ үед Монгол шиг эдийн засаг нь уул уурхайгаас хэт хамаардаг орон яаж ажиллах ёстой вэ?

-Монгол Улс эдийн засгаа аль болох төрөлжүүлэх хэрэгтэй. Мэдээж өнөөдрийн хувьд уул уурхай Монголд чухал. Гэхдээ эндээс олж байгаа баялгаа эдийн засгийг бүхэлд нь хөгжүүлэхэд зориулах нь илүү ач холбогдолтой. Монгол Улс тогтвортой хөгжихөд эдийн засгийн төрөлжилт гол үүрэг гүйцэтгэхээр байна.

-Монгол Улс Хятадын эдийн засгийн өсөлтөөс хэрхэн "хожиж" болох вэ?

-Хятадын өсөлт Монголын хувьд боломж. Дэлхийн улс орнууд Хятадын өсөлтийг боломж гэж харах хэрэгтэй. Хятад бол Монголын экспортын бүтээгдэхүүний гол хэрэглэгч учир богино хугацаандаа ашигтай байх нь ойлгомжтой. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» МОНГОЛБАНК

1.4

Их наяд төгрөг Монголбанкны нэг долоо хоногтой үнэт цаасны үлдэгдэл 1.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна.

» АРИЛЖАА

1.82

Хувь. Монголын хөрөнгийн бирж пүрэв гарагийн үнэт цаасны арилжаагаар 25 хувьцаат компанийн нийт 116,300 ширхэг хувьцаа арилжлаа. Хөрөнгийн биржийн индекс энэ өдөр 925.76 нэгж болж 1.82 хувиар өсөв. Ингэснээр зах зээлийн үнэлгээ 1.7 их наяд төгрөг боллоо. Ханшийн өөрчлөлтийн хувьд 20 компанийн хувьцааны ханшид өөрчлөлт орсон байна. Үүнээс "Тавантолгой" компанийн хувьцаа хамгийн өндөр буюу 14.96 хувийн өсжээ.



» ТӨСӨЛ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2013 онд шинэчлэн батлагдсан. Үүнтэй холбогдуулан "Хориг арга хэмжээ хэрэгжүүлэх тухай журам" гэж нэрийг нь өөрчлөн шинэчлэн боловсруулжээ.

» УУЛ УУРХАЙ

19.46

Сая тонн нүүрс. БНХАУ долдугаар сард 19.46 сая тонн нүүрс импортолжээ. Энэ нь өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 8.25 хувиар бага дүн болохыг тус улсын Гаалийн ерөнхий газар мэдээллээ. Мөнгөн дүнгээр тооцвол өнгөрсөн сард Хятадын нүүрсний импорт 1.6 тэрбум ам.долларт хүрч, жилийн өмнөхөөс 52.38 хувиар өсжээ. Дунджаар тооцож үзвэл нэг тонн нүүрсний ханш 82.22 ам.доллар байна.

» ТАЙЛАН

33.1

Сая төгрөг. "Мерекс" хувьцаат компани энэ оны хоёрдугаар улиралд 33.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Бетон зуурмаг үйлдвэрлэлийн "Мерекс" компани нэг тэрбум гаруй төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Борлуулалтын орлого нь жилийн өмнөх үеэс даруй 725.4 сая төгрөгөөр өсжээ.

» ДААТГАЛ

11

Хувь. Даатгалын компаниудын хураамжийн орлого 11 хувиар өсөж, 18.3 тэрбум төгрөгт хүрэв.

ВАЛЮТЫН ХАНШ

Ам.доллар	2443.52
Евро	2863.81
Япон иен	22.21
ОХУ рубль	40.80
БНХАУ юань	366.04
БНСУ вон	2.14

МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ
MONGOLIAN MORTGAGE CORPORATION

"МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ ОССК " ХХК ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ШАЛГАРУУЛЖ АВНА

ГҮЙЦЭТГЭХ ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: Байгууллагын дотоод үйл ажиллагаа, хүний нөөц, бизнесийн процесстой холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж үнэлэлт, дүгнэлт өгч, санал боловсруулах, эрсдэлийг бууруулах, таниулах арга хэмжээ авах болон нэгдсэн үйл ажиллагааны эрсдэлийн холбогдох бүртгэлийг хөтлөх, эрсдэлийн аппетитийн зохистой байдлыг хянах, тайлагнах, нэгдсэн аргачлал, журам, заавар боловсруулан батлуулж үр ашигтай тогтолцоог бэхжүүлэх.

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:
• Банк, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр их дээд сургууль төгссөн;
• Эрсдэлийн удирдлагын чиглэлээр 3-с доошгүй жил ажилласан туршлагатай;
• Санхүүгийн мэргэжлийн англи хэлний бичгийн болон ярианы ахисан түвшний мэдлэгтэй;
• Хариуцсан асуудалд шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, илтгэх чадвартай;
• Зөв бичгийн дүрэм, хэл найруулгын сайн мэдлэг чадвартай;
• Компьютерийн хэрэглээний программыг бүрэн эзэмшсэн;

ДАВУУ ТАЛ:
• Гадаадад их дээд сургууль төгссөн бол давуу тал болно.
• Олон улсын Базелын хорооны чиглээрх сургалтанд хамрагдсан бол давуу тал болно.

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:
• Хариуцсан ажилдаа идэвхи санаачлагатай, бүтээлч сэтгэлгээтэй, хариуцлагатай, ажлын цаг ашиглалтын зохион байгуулалт сайтай;
• Ажлын ачаалал даах чадвартай;
• Нууц хадгалах чадвар, дадалтай;
• Байгууллагад тогтвор суурьшилтай ажиллах;
• Харилцааны соёлтой, хувийн зохион байгуулалт сайтай;
• Багаар болон бие даан ажиллах чадвартай;
• Ёс зүйн өндөр шаардлага өөртөө болон бусдад тавьдаг;

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:
• Анкет (www.mik.mn вэб сайтаас татаж авна уу);
• Ажилд орохыг хүссэн өргөдөл (гараар бичсэн);
• Дипломны хуулбар (нотариатаар баталгаажуулсан байх);
• Иргэний үнэмлэхний хуулбар;
• 3 үеийн түүх (гараар бичсэн);
• Өмнөх хийж байсан ажил, туршлагын талаарх товч мэдээлэл.
• Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй иргэд материалаа delgermurun@mik.mn хаягаар болон СБД-ийн 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа хөгжлийн банкны оффисийн 10-р давхарт 2017 оны 08-р сарын 17-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Жич: Анкетийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажил горилогч нартай холбоо барина.

Утас: 11-318454 (827) **Вэбсайт: www.mik.mn** **И-мейл: info@mik.mn**

БИЗНЕС

"Nissan" хохирлыг барагдуулахад 98 сая ам.доллар зарцуулна

Б.Ариунболд
Шинжээч

"Nissan Motor" компани "Takata"-ийн аюулгүйн дэрний улмаас хэрэглэгчдэд учирсан хохирлыг барагдуулахад 98 сая ам.доллар зарцуулахаар болжээ. Тус тохиролцоог шүүхээр хэлэлцсэн бөгөөд үүний дагуу эргүүлэн татсан автомашины аюулгүйн дэрийг түргэн хугацаанд сольж, хэрэглэгчдэд нөхөн төлбөр олгох юм. Мөн энэ тохиролцоо нь тавдугаар сард дөрвөн автомашин үйлдвэрлэгчийн хийж байсан 533 сая ам.долларын тохиролцоотой ижил гэдгийг албаныхан дурджээ. Шүүхээс шийдвэрлэсний дагуу "Nissan" компани 4.4 сая ширхэг автомашины асуудлыг шийдвэрлэхээр болсон. Өнгөрсөн зургадугаар сарын сүүлээр л гэхэд тус компани "Takata"-ийн аюулгүйн дэрний асуудлаар эргүүлэн дуудсан автомашинуудын ердөө 29.9 хувийг засварлаад байжээ.

ТЕХНОЛОГИ

Сансрын хөлөгт ашиглах цэнэг хураагуур бүтээнэ

Н.Алтан
Шинжээч

Японы эрдэмтэд сансрын хөлөгт ашиглах боломжтой цэнэг хураагуур бүтээх ажлыг эхлүүлжээ. "Hitachi Zosen" компанийн бүтээж буй энэхүү цэнэг хураагуур илүү аюулгүй, найдвартайгаас гадна эрчим хүчний нягтаршил өндөр гэдгээрээ онцлог юм. Мөн энэхүү цэнэг хураагуур нь одоо ашиглаж буй литийн ион баттерейтэй төстэй боловч литийн ион нь хатуу төлөвт байгаа учраас ялгаатай. Хатуу төлөвт байгаа литий нь зарцуулалт удаан байдгаас гадна агаарын эрс тэс хэмд ажиллах чадвартай. Иймээс сансрын хөлөгт ашиглахад хамгийн тохиромжтой гэж "Hitachi Zosen" компаниас мэдэгджээ. Гэхдээ ийм төрлийн цэнэг хураагуурыг хэрэглээнд нэвтрүүлэхэд тодорхой хугацаа шаардлагатай бөгөөд 2020 оноос хэрэглэгчдийн гарт хүрэх боломжтой гэж мэдээллээ.

Лавлах

СПОРТ

М.Түмэнбаяр "Гранпри"-д оролцоно

Б.Мөнх
ЗГМ

Үндэсний шигшээ багийн гишүүн, "Алдар" спорт хорооны таеквондогийн тамирчин М.Түмэнбаяр ДАШТ-ий шагналт тавдугаар байрт шалгарлаа. БНСУ-д зохиогдсон "Корёо опэн" тэмцээнээс алтан медаль хүртэж тус тэмцээний шилдэг тамирчин болсон. Ийнхүү тэрбээр олимпын чансааны 58 кг жинд 1408 тамирчнаас 28 дугаарт эрэмбэлэгдэж, "Гранпри" тэмцээнд оролцох эрхээ авсан анхны монгол тамирчин боллоо. Таеквондогийн спортын онцлог нь олимпын чансааны эхний 32 дугаарт багтсан шилдэг тамирчид "Гранпри" ангиллын тэмцээнд өрсөлдөг. Мөн олимпын чансааны эхний зургаад эрэмбэлэгдсэн тамирчид олимпын наадамд оролцох эрхийг шууд авдаг. Мөн тамирчид тухайн тивийнхээ олимпын эрхийн төлөө тэмцээнд зөвхөн алт, мөнгөн медаль хүртсэнээр олимпт оролцох эрхээ авдаг өндөр шалгууртай спортын төрөл юм. [ЗГМ]

ЦАГ АГААР

Ихэнх нутгаар бороо орно

Баруун болон говийн бүсийн зарим нутгуудаар борооны өмнө салхи түр зуур 14-16м/с, 8, 12-нд 18-20м/с хүрэх ба төвийн болон зүүн бүсийн аймгуудаар түр зуур 18-20м/с хүрч ширүүсэх төлөвтэй байна. Цаг агаарын урьдчилсан мэдээгээр хангайн уулархаг нутгаар шөнөдөө 8-13, өдөртөө 22-27 хэм, Хөвсгөл, Хэнтийн уулсаар шөнөдөө 2-7, өдөртөө 13-18 хэм дулаан байна. Харин говийн нутгуудаар шөнөдөө 15-20, өдөртөө 22-27 хэм дулаан байна. Иймд ихэнх нутгаар дуу цахилгаантай аадар бороо орох тул гэнэтийн үер ус, мөндөр, нөөлөг салхины аюулаас сэрэмжтэй байхыг ЦУОШГ-аас анхааруулж байна. [ЗГМ]

зөвлөгөө

Тарвасны гайхамшиг

Испанийн эрдэмтэд булчин өвдсөн үед тарвас, эсвэл түүний шүүсийг хэрэглэх нь өвдөлт намдаадаг гэж үзжээ. Тарвас нь хүнд дасгал, хөдөлгөөн хийсний дараа булчингийн эд эсийг сэргээдэг амин хүчил агуулдаг. Энэ нь гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн сайжруулж, биеэс муу өөх тос болон булчинд илүүдсэн сүүний хүчлийг гадагшлуулдаг байна. Улмаар шээс хөөх, шар хөөх, халуун бууруулах, цангаа тайлах бөгөөд элэг, цөс цэвэрлэж, чулуу үүсэхээс урьдчилан сэргийлдэг. Түүнчлэн ходоодны шарх, цус багатай, элэг, цөс өвддөг хүмүүс шинэхэн тарвас идвэл сайн. Өвчтөний биеийн байдлаас хамааран 7-10 хоног тарвасны мацаг барьж болдог байна. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	**08:00** "Робо-кон-2017"	**08:00** "Bloomberg Daybreak Asia"	**09:05** "Бяцхан оцон шувуу Пороро" хүүхэлдэйн кино	**09:30** "Тог тог тог" хүүхдийн нэвтрүүлэг
12.00	**11:00** "Ярилцлага" (МУ-н Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга оролцоно)	**11:30** "Шилдэг санаа" нэвтрүүлэг	**13:00** "Кино миний амьдрал" нэвтрүүлэг	**12:30** "Өнөө өглөө" нэвтрүүлэг
14.00	**13:20** MYOHT сан хөмрөгөөс: "Тамын дурлал" жүжиг	**14:00** "Дэвид Рубенштэйний шоу" нэвтрүүлэг	**14:10** "Аяыг таа" шоу нэвтрүүлэг	**16:40** Үлгэрийн цаг
18.00	**16:50** "Ирээдүйд илгээх захидал" сурагч солилцоо	**17:00** "Bloomberg Surveillance"	**16:55** "Дэлхийн атлас" танин мэдэхүйн нэвтрүүлэг	**17:30** "Мулан" хүүхэлдэйн кино
20.00	**20:00** "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөр	**20:00** "Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг	**20:35** Аугаа уран зургууд	**20:00** Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
22.00	**21:10** "Баасан гараг" цэнгээнт нэвтрүүлэг	**22:00** "Гол сэдэв" нэвтрүүлэг	**20:50** "Ялалт" ток шоу	**23:30** Удшийн мэдээ

ОНЦЛОХ ҮЗВЭР

Урлагийн гайхамшгийг мэдрүүлнэ

Уран зураг, гэрэл зураг, шивээс, боди арт чиглэлийн бүтээлүүдийг нэг дор дэлгэж, урлагийн төрлүүдийн төгс зохицол, онцлог гайхамшгийг хүн бүрт мэдрүүлэхээр "Skin and Canvas" чөлөөт үзэсгэлэн Монголд анх удаа болох гэж байна. Уг арга хэмжээ энэ сарын 19-нд Хүүхдийн парк дахь Хар сувд ресторанд болох бөгөөд бүх насныхан нээлттэй аж. Тасалбарын үнэ 8000 төгрөг. Харин 15-аас доош насны хүүхдүүд үнэгүй оролцох боломжтой. [ЗГМ]

ҮЗВЭР

ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН
Япон улсын Элчин сайдын яамнаас тус улсын соёл сурталчлах өдөрлөгийг энэ сарын 12-нд зохион байгуулах гэж байна. Өдөрлөгийн үеэр япон дууны тэмцээн зохион байгуулж, ялагчийг тус улсад долоо хоног аялах эрхээр шагнах юм.

ӨРГӨӨ КИНО ТЕАТР
Найруулагч Дэвид Ф.Сандбергийн бүтээл "Annabelle" аймшгийн киноны хоёрдугаар анги өнөөдөр нээлтээ хийнэ.

НАЙРАМДАЛ ЗУСЛАН
Олон улсын хүүхдийн спортын VII их наадам энэ сарын 12-17-нд Улаанбаатар хотноо болно. Уг наадамд Монгол, ОХУ, БНХАУ-ын 1100 тамирчин 11 спортын төрлөөр өрсөлдөх юм.

МИШЭЭЛ ЭКСПО
Хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцасны үзэсгэлэн худалдаа энэ сарын 21-23-нд болно. Уг үзэсгэлэн худалдаа 15.00-24.00 цаг хүртэл үргэлжилнэ.

ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН
НҮБ-ын залуучуудын зөвлөх хорооноос "Mongolian youth festival 2017" арга хэмжээг маргааш зохион байгуулна.

ТӨВ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН
Орчин үеийн хөгжмийн урсгалуудыг нэгтгэсэн "Хүннү" наадам энэ сарын 25,26-нд болно. Уг наадамд хип хоп урсгалын шилдэг хамтлаг, дуучид болон гадаадын шилдэг DJ нар уран бүтээлээ толилуулах бөгөөд 16-аас дээш насныхан оролцох боломжтой. Тасалбарын үнэ 10-15 мянган төгрөг ба алтан үзэгчийг нэг өрөө байраар шагнана.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
2. Тэмцлийн нэгэн хэлбэр
3. Төрийн хөгжимчин
4. Хамгийн олон малтай аймаг
5. Намхай аваргын сахилын нэр
9. Монгол Улс, монголчуудад байх хамгийн элбэг зүйл
11. Ардын засгийн анхны Ерөнхий сайд
12. Энэ жил түрүүлснээр дэлхийн аваргын цомыг гурвантаа хүртсэн Английн снукер бильяардын тамирчин

ХӨНДЛӨНГӨӨР:
1. Японы хэвлэл, мэдээллийн томоохон байгууллага
6. Дорнын их яруу найрагч
7. Цэргийн ангийн салбар нэгж
8. Африкийн улс
10. 1945 онд байгуулагдсан олон улсын хамгийн том байгууллагын товчилсон нэр
12. Монгол бөхийн өргөөний үүргийг гүйцэтгэж байсан байрны товчилсон нэр
13. Алуурчин
14. Үндэсний хөгжим

Өмнөх дугаарын хариу / 08.09

У				Х				А
Н	А	Й	Р	А	М	Д	А	Л
Г	■	Р	■	Н	■	О	■	Т
А	З	■	Ш	О	Р	■	Ф	А
Р	■	М	■	Й	■	С	■	Н
■	Б	Я	Р	■	У	У	Ж	■
С	■	Н	■	Н	■	М	■	Г
И	■	Г	О	О	Н	Ь	■	У
М	■	А	■	Ё	■	Я	■	У
Б	Ү	Т	Э	Н	Б	А	Я	Р
А								С

ЗГМ: СУДОКУ

		3		7		4	1	
1	2		3				5	
		5			9			
		1		3				
7		4				9		8
				8		1		
			2			8		
	1				5		3	4
	8	2		4		6		

9	3	6	8	1	7	2	4	5
7	5	1	9	2	4	6	8	3
4	8	2	5	6	3	7	9	1
5	9	8	2	7	6	3	1	4
2	1	4	3	8	9	5	6	7
6	7	3	1	4	5	8	2	9
3	6	7	4	9	2	1	5	8
1	4	5	6	3	8	9	7	2
8	2	9	7	5	1	4	3	6

(Өмнөх дугаарын хариу)

ЗУРХАЙ



Билгийн тооллын 19
Зуны адаг улаагчин хонь сарын дөрвөн ногоон мэнгэтэй, цагаан морь өдөр.
Үс засуулбал: Сайн нөхөртэй нөхөрлөнө
Наран ургах, шингэх: 05.46-20.08
Барилдлага: Идэр
Шүтэн барилдлага: Нэр өнгө
Суудал: Төмөр

Аргын тооллын наймдугаар сарын 11, Сугар гараг. Билгийн тооллын 19, Могойг хүлэгч одтой, цагаан морь өдөр.

Өдрийн наран 05.46 цагт мандаж, 20.08 цагт жаргана. Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лус тахих, тангарагаа буцаахад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сэвтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал сайн нөхөртэй учирна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

VIII.11	VIII.12	VIII.13	VIII.14	VIII.15
19° / 10°	23° / 10°	26° / 10°	27° / 13°	25° / 13°
12 м/с / 10 м/с	9 м/с / 8 м/с	8 м/с / 7 м/с	7 м/с / 9 м/с	8 м/с / 6 м/с
Түр зуурын бороотой	Түр зуурын бороотой	Бага зэргийн бороотой	Үүлшинэ	Үүлшинэ



ЗГМ: КОМИКС

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Москва	13.50	14.28
Эрээн-УБ	18.00	11.15
УБ-Бээжин	07.15	14.04
Хөххот-УБ	22.50	11.15
УБ-Хөххот	20.00	20.49
Эрхүү-УБ	15.35	06.20
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрдэнэт-УБ	19.10	05.48
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Замын-Үүд-УБ	17.35	08.55
УБ-Замын-Үүд	17.20	07.05
Сайншанд-УБ	20.25	07.01
УБ-Сайншанд	09.15	19.15

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

Сөүл-УБ	01.35	04.05
УБ-Сөүл	08.45	12.50
Токио-УБ	14.40	19.10
УБ-Токио	07.55	13.40
Бээжин-УБ	09.30	12.00
УБ-Бээжин	06.10	08.25
Хонгконг-УБ	18.30	23.10
УБ-Хонгконг	13.00	17.30
Москва-УБ	19.25	06.35
УБ-Москва	09.15	10.55

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

BBM©

Дижитал Америкийн "Их, бүр их"

◀1

Үүний зэрэгцээ манлай салбар дотроо манлай компаниуд л ашиг орлогын дийлэнхийг хамна. АНУ-ын компаниуд дотор хамгийн ашигтай ажилладаг 10 хувьд хамрах хэсгийн орлого нь дундаж компаниудынхаас даруй найм дахин их. Гэтэл 1990-ээд оны үед энэ хоёр үзүүлэлт хоорондоо ердөө гурав дахин зөрөөтэй байсан юм. Ажилтан, ажилтнуудаа лут цалинжуулдаг энэхүү супер орлоготой компаниудын өрсөлдөгч нар нь ийм хэмжээний хөлс амлаж дийлэхгүй.

Ажилчдын цалингийн зөрөө 1970-аад оноос хойш компани хоорондын цалингийн зөрөөтэй илүүтэй уялдах болсныг Бонн хотноо байрладаг Хөдөлмөрийн эдийн засгийн хүрээлэнгийн судалгаагаар тодорхойлжээ. Манлай компаниудын цалинг бусад ердийн өрсөлдөгч нарынхтай нь харьцуулсан энэ зөрөө АНУ-ын үнэмлэхүй олонхийн дунд үүсээд байгаа эрх тэгш бус байдлын шалтгаан.

Манлай салбар болоод компаниуд нь эдийн засгийн бялуунаас том хувь хүртэж буйн бас нэг шалтгаан бол дижиталчлал. МакКинсийн хүрээлэнгийн судалгааг үзвэл технологийн дэвшлийг илүү шаламгай нэвтрүүлж буй компаниудын ашиг орлого л онцгой хурдтай өсөж байна. Ийм судалгааны жагсаалтын тэргүүн байрыг технологи, санхүүгийн компаниуд эзэлдэг. Гэтэл ажлын байрны ихэнхийг бүрдүүлдэг жижиглэн худалдаа, боловсрол, засаг захиргааны салбар нь бизнесийн загвартаа дижитал технологи нэвтрүүлэхдээ хавьгүй удаан. Ингээд эд баялгийн ихэнхийг хүртэх мөртлөө цөөхөн ажлын байр үүсгэдэг лут бүтээлч оргил хэсэг, хөшүүн удаан ёроол хэсэг гэсэн хоёр салаа эдийн засгийн бүтэц бий боллоо.

Дүнд нь зах зээлийн хачирхалтай шинэ чиг хандлага үүсэж, 1980-аад оноос хойш болоод ирсэн Уолл Стрийт, ердийн олонх хоёрын харилцаа тасрах аюултай болж хувирав. Ажиллагсдын олонх тааруу байхад ч мэдээллийн технологийн бизнес эрхлэгч цөөн тооны манлай компаниудаас шалтгаалан зах зээл бүхэлдээ жигтэйхэн сайн байж болоод байна. Ийм хачин үзэгдэл АНУ-аар тогтохгүй. БНХАУ зэрэг эдийн засгийн өсөлт сайтай бусад улсын "зах зээлд ердөө технологи гол зүйл болж хувирсан" талаар Morgan Stanley Investment Management-ийн хөгжиж буй зах зээл хариуцсан захирал Рүчир Шарма тайлбарлав.

Аварга хэмжээтэй өгөгдлийг дангаараа хянаж буй Google, Facebook, Apple, Amazon зэрэг технологийн компаниудынхыг эс тооцвол аливаа технологийн компанийн хувьцааны үнэлгээ арай хэтийдсэн мэт санагддаг. Мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэх бодлогоос холдож байж энэхүү хөөсийг хагалах боломжтой ч технологийн компаниудын зохицуулалтын орчныг өөрчилдөггүй л юм бол ойрын хэдэн жилдээ энэ нь боломжгүй. Юутай ч байдал өөрчлөгдөх үед хөрөнгө оруулагч нар нь хэрхэхийг харах нь сонин байх болно.

Технологийн зарим аварга компани "ялагч бүгдийг хамах" байр сууринаас хөндийрч, эдийн засгийн илүү өргөн цар хүрээтэй эко тогтолцоонд байр сууриа эзлэх үүрэгтээ анхаарч эхэллээ. Хятадад Alibaba компани хөдөө орон нутгийн худалдаачдыг эдүгээ цагт ашиг орлого олж чадах цор ганц салбар болсон дижитал технологид ойртуулах үүднээс алслагдмал 1000 гаруй газарт өргөн зурвасын интернэт холболт нэвтрүүлэх ажил санаачиллаа.

Эдийн засгийн хувьд улам салаа, улс төрийн хувьд улам туйлширмал болж буй дэлхий ертөнцөд ингэж ажиллах нухацтай үндэс хангалттай бий. АНУ-ын технологийн компаниуд ч энэ бүхнийг анхаарах ёстой болов уу.

FT

Солонгосын хямралыг дагаад Швейцар франк чангарав



bloomberg.com

Майкл Хантер, Мехрин Хан

АНУ, БНАСАУ-ын хооронд дайсагналцсан үг яриа хурцдахын хэрээр хөрөнгө оруулагчид хувьцаанаас зайлсхийх хандлага нэмэгдэж, дэлхийн зах зээл дээр аюулгүй валют руу хошуурч эхэлснийг Швейцарын франк тэргүүлж байна. Пхеньян, Вашингтон хоёр үгээр сөргөлдөх завсар АНУ-ын хөрөнгийн зах зээлийн гол индексүүд суларсны дараа Европын хөрөнгийн биржүүд алдагдал хүлээж эхэллээ. Хямралын үед тогтвортой валют гэж алдаршсан Швейцарын франкын евротой харьцах ханш хамгийн ихээр буюу 1.5 хувиар чангарсан байна. Харин АНУ-ын доллартай харьцах ханш нь 1.4 хувь өслөө.

2015 оны нэгдүгээр сард Швейцарын төв банк франкын ханшийг еврогоос салгаж, чөлөөтэй болгох шийдвэр гаргаснаас хойш нэг өдөрт гарсан хамгийн их өсөлт болсон байна. Үүний зэрэгцээ алтны үнэ хоёр сарын дээд түвшиндээ буцан ирж, хөрөнгө оруулагчдын дунд Японы иен болон Засгийн газрын найдвартай бондууд эрэлттэй байлаа. Азийн арилжаанд Өмнөд Солонгосын хөрөнгийн биржийн үндсэн индекс нэг хувиар доошилж, валютын ханш нь мөн 0.8 хувиар буурав. Токиогийн Topix биржийн индекс лхагва гарагт мөн 1.1 хувийн уналттай хаагджээ.

Standard Life хөрөнгө оруулалтын компанийн дэлхийн стратегийн захирал Эндрю Миллиган "Ийнхүү үгээр дайтаж байгаа нь зах зээлд геополитикийн эрсдэл тулгарч буйг сануулаа. Үүнд хөрөнгө оруулагчид онц анхаардаггүй авч заримдаа улс төрийн эрсдэлийг тооцох ёстой болдог. Зах зээл дэх хөдөлгөөнийг жижиг гэж болохгүй. Гэхдээ энэ нь хэмжихүйц бөгөөд үүнд Өмнөд Солонгосын Kospi индекс ба вон ч хамаарна" гэжээ. Лхагва гарагт Ерөнхийлөгч Трамп Умардын заналыг "догшин галаар угтана" гэж хэлсний дараа АНУ-ын хувьцааны бенчмарк өдрийн төгсгөл рүү доош гулсах хандлагатай байсан юм.

FT

Умардын заналд өртсөн бяцхан арал

BBM©

Катрина Мансон

Номхон далай дахь Гуам арлын цагаан элстэй, шүрэн эргийг "Дурлалт хосын цэг" гэмээр байдаг ч цөмийн зэвсгээр далайлгагч хоёр сөргөлдөгчийн бай болчихоод байна. Ким Жон Ун арлыг довтлохоор заналхийлсний дараа АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон америкчуудын амар амгаланг хамгаалахаа илэрхийлэхийн тулд Гуамд буугаад мордохоос илүү бэлгэдэлтэй газар олоход бэрх. Хойд Солонгосын заналд өртсөн АНУ-ын эзэмшлийн бяцхан арал ганц шөнийн дотор Пхеньяныг сөрөх америкчуудын зориг эрмэлзлийн илэрхийлэл болж хувирсан юм.

Мягмар гарагт Америкийн нисэх хүчин тус арал дахь Андерсений баазаас B-1B хол нислэгийн хоёр бөмбөгдөгч онгоц илгээж, Япон, Өмнөд Солонгосын байлдааны онгоцуудын хамтаар Солонгосын хойг дээгүүр эргүүлийн нислэг үйлдэв. Японы арлуудаас урагш 1600 бээр орчимд оршдог 200000 мянган хүн амтай Гуам арал бол АНУ-ын гадаад далай дахь чухал цэргийн баазуудын нэг. Энд агаарын болон тэнгисийн цэргийн байгууламж тусдаа байрлаж, 6000 цэргийн албан хаагч, тусгай албаныхан, цөмийн шумбагч завь үүрэг гүйцэтгэж буй. Пентагон тус арлаас байнгын сургуулилалт хийж, Хойд Солонгосын цөмийн ба пуужингийн аюулаас бүс нутгийн холбоотнуудаа хамгаалах үүрэг хариуцлагаа баталгаажуулдаг.

Гуам 1898 оноос АНУ-ын эзэмшилд ирсэн бөгөөд дэлхийн хоёрдугаар дайны үед Японд эзлэгдэж байжээ.Тус арлын стратегийн байрлал нь гадаадын Засгийн газруудтай бааз байгуулах өртөг ихтэй, тогтвор муутай гэрээ хэлцэл хийхээс чөлөөлдөг аж. Азийн бүс нутагт ойр оршдог нь арлын ач холбогдлыг өсгөж байна. Cato Institute-ийн шинжээч Жон Гласиер "Гуамд байрладаг тусгай хүчний цэргүүдийг Ази Номхойн далайн аль ч цэгт агаараар болон далайгаар 5-14 хоногийн дотор хүргэж болно" гэж ярьсан байна.

Тэрбээр аралд байрладаг шумбагч завиуд Азийн зүүн эрэгт тав хоногийн дотор очих боломжтойг онцлов. Энэ нь Хавайд хүрэхээс гурван хоног, Сан Диегод очихоос 10 хоногийн наана юм. Гэвч Гуамын оршин суугчид шөргөн галд өртөж болзошгүй байгаад сэтгэл дундуур буй нь мэдээж. Гуамаас сонгогдсон конгрессын гишүүн эмэгтэй Маделин Бордалло Трампын мэдэгдлийг "тусгүй" гэж нэрлэсэн бол арлын захирагч Эдди Калво нэн даруй Цагаан ордон болон Америкийн цэргийн командлагчдаас баталгаа гаргаж өгөхийг шаардаж, "Бид зөвхөн цэргийн байгууламж биш шүү" хэмээн сануулжээ.

FT

BHP Цахилгаан машины зай хураагуурын зах зээлд

Жэйми Смит

Баруун Австрали нь зуу гаруй жилийн турш алт, төмрийн хүдэр олборлогчдын диваажин болж ирлээ. Гэтэл дэлхий ертөнц цахилгаан автомашин болон эрчим хүч хадгалах шинэ технологид шилжиж буйтай уялдан тус бүс нутгийн литий, кобальт, никелийг олборлох өрсөлдөөн эрчээ аваад байна.

BHP Billiton компани дэлхийн сульфат никелийн гол ханган нийлүүлэгч болох төлөвлөгөөтэй байгаагаа лхагва гарагт мэдэгдэв. Сульфат никел нь цахилгаан машины эрчим хүчний гол үүсгүүр-литий ионы зай хураагуурын үндсэн түүхий эд юм.

Тус компани жилдээ 100 мянган тонн сульфат никель үйлдвэрлэх хүчин чадалтай шинэ үйлдвэрийг 43 сая ам.долларын өртгөөр байгуулж байгаа. Уг үйлдвэр 2019 оны дөрөвдүгээр сард ашиглалтад орно.

"Шинэ эрчим хүчний хувьсгал болж буйтай уялдан сульфат никелийн эрэлт дундаж хугацаандаа эрс өснө" хэмээн BHP Nickel West-ийн ерөнхийлөгч Эдуард Хэгель баруун Австралийн Калгурлид болсон Diggers & Dealers уул уурхайн хуралдааны үеэр Financial Times-д тайлбарлав.

Tesla, Panasonic зэрэг компанийн ачаар никелийн орц ихтэй зай хураагуурын хэрэглээ нэмэгдэх тооцоог тус компани гаргажээ. Литий-ионы зай хураагуурт дээд зэрэглэлийн никель ашигладаг. Ийм ч учраас BHP компани үйлдвэрлэдэг никелийнхээ ихэнхийг ашиг багатай зэвэрдэггүй гангийн зах зээлд бус, ашиг өндөр эрчим хүчний хадгалуур, цахилгаан машины зах зээлд нийлүүлэхээр төлөвлөжээ.

Эдүгээ тус компани никелийнхээ 10 хувийг зай хураагуурын зах зээлд зориулдаг. Ойрын таван жилд тус компани уг үзүүлэлтийг 90 хувьд хүргэх зорилттой.

BHP нь Калгурли дахь Nickel West охин компаниа чухал бус салбар гэж үзээд зарах арга эрэлхийлж байсан юм. Гэтэл сульфат никелийн эрэлт ихэссэн нь байдлыг өөрчиллөө.

Дэлхийд 2025 он гэхэд цахилгаан авто машины борлуулалт 20 дахин нэмэгдэх тооцоог UBS гаргаад байна. Үүнтэй уялдан зай хураагуурт ашигладаг литий, кобальт, никель, бал чулуу зэрэг түүхий эдийн эрэлт эрс өсөхөөр байгаа юм. Баруун Австрали нь эдгээр түүхий эдийн арвин нөөцтэй тул олборлогчдын түншүүд нь бүс нутагт уурхай нээхэд хамтран ажиллах сонирхолтой боллоо.

Дэлхийн литийн гол компани - Sociedad Quhmica y Minera de Chile баруун Австралид Kidman Resources-ийн Mt Holland lithium төслийн хувьцааны 50 хувийг авахаар 110 сая ам.доллар төлөв. Pilbara Minerals компани 2018 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн 234 сая ам.долларын өртөгтэй литийн уурхайд зориулан 100 сая ам.доллар хуримтлуулаад байна.

"Австрали литийн үйлдвэрлэлээр хэдийнэ дэлхийд тэргүүлэгч болсон. Одоо литийн дөрвөн уурхай ажиллаж байгаа. Цаашид дахиад дөрвөн уурхай ашиглалтад орно" хэмээн Калгурлийн ойролцоох Mt Marion литийн уурхайн хувьцааны 13.8 хувийг эзэмшдэг Neometals компанийн гүйцэтгэх захирал Крис Рид өгүүллээ.

US Geological Survey-ийн судалгаагаар Австрали нь 2016 онд 14300 тонн литий үйлдвэрлэж дэлхийд тэргүүлсэн. Хоёр, гуравдугаар байранд 12000, 5700 тонн тус тус үйлдвэрлэсэн Чили, Аргентин орж байна.

Өнгөрсөн онд дэлхийн литийн хэрэглээ 14 хувиар өсөж 37800 тоннд хүрсэн. Үүнтэй уялдан Хятадын спот зах зээлд тонн нь 20000 ам.доллар болж үнэд орлоо.

Зэс, никелийн үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн болох кобальт ч литий-ионы зай хураагуурын чухал бүрдэл тул эрэлт нь эрс ихсээд байна. Энэ онд Лондоны металлын биржид кобальтын үнэ 73 хувиар өсчээ.

FT

Сурталчилгаа

АБСОЛЮТ ЭЛИТ
АХЛАХ СУРГУУЛЬ

2017-2018 оны хичээлийн жилийн элсэлтээ авч байна.

ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛУУД

- Англи хэлний бүх шатны түвшингээс TOEFL & IELTS-н шалгалтуудад хамгийн шилдэг тусгай хөтөлбөрөөр бэлтгэнэ
- АНУ, Япон улс гэх мэт гадаадын дээд сургууль төгссөн Монгол багш нар, олон улсын TESOL, TEFL-н зэрэгтэй гадаад багш нар хичээлийг удирдан явуулна
- Хичээлийн хоцрогдол арилгах давтлага үнэ төлбөргүй
- Орчин үеийн тохилог анхи танхим, иж бүрэн тоноглогдсон лаборатори
- 12-р анги төгсөж буй сурагчид бүгд албан ёсны ITP (TOEFL) оноотой төгсөнө

IELTS TOEFL SAT
ACT ЭЕШ Монбушо

шалгалтуудад гүнзгийрүүлэн бэлтгэх сургалттай
10, 11, 12-р анги

БИДНИЙ ТУХАЙ

АБСОЛЮТ ЭЛИТ ахлах сургууль нь АБСОЛЮТ төвийн 15 жилийн ойн босгон дээр шинээр үүсгэн байгуулагдлаа. Бид 16 жилийн хугацаанд олон мянган суралцагчдыг англи хэлний академик түвшний мэргэжилийн шалгалтуудад амжилттай бэлтгэн TOEFL, IELTS-н Монголын рекорд оноог 5 удаа шинэчлэн тогтоосон юм. Үүний үр дүнд Монгол улс,АНУ, Япон улс(Монбүшо),БНХАУ, ОХУ, Австрали, Европын холбоо гэх мэт орнуудын Засгийн Газрын 100% тэтгэлэгт хөтөлбөрүүдэд амжилттай хамруулснаар дэлхийн эхний 20-д багтдаг нэр хүндтэй сургуулиудад тэтгэлэгээр суралцах цуваа тасрахгүй үргэлжилсээр байна. Мөн англи хэлний улс, олон улсын олимпиад, гадаад харилцааны сайдын нэрэмжит олимпиадуудад алт, мөнгө, хүрэл медалиуд, ЭЕШ-нд 800 онооны тогтмол амжилтууд удаа дараа хүртэж чаддаг билээ. Уг амжилтан дээр үндэслэн АБСОЛЮТ ЭЛИТ ахлах сургууль нь сурагчдаа TOEFL,IELTS-н шалгалт, SAT, ACT, Монбушо болон ерөнхий эрдмийн хичээлүүдийн шалгалтанд амжилттай бэлтгэн ЕБС-лаа төгсөхдөө өндөр хөгжилтэй оронд 100% тэтгэлэгээр суралцуулах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

БИДНИЙ АМЖИЛТУУДААС

77118288 , 99008158 БГД 3-р хороо Замчдын-17